



**УНТЭ-ИЙН ДЭРГЭДЭХ ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ ЁС ЗҮЙН  
САЛБАР ХОРООНЫ ГИШҮҮДИЙН СОНГОН ШАЛГАРУУЛАЛТАД  
ОРОЛЦОХЫГ УРЬЖ БАЙНА. /8 гишүүн/**

**Салбар хорооны гүйцэтгэх үүрэг:**

- Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээний хэрэгжилтийг зохион байгуулах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн алдаатай холбоотой гомдол, мэдээллийг холбогдох хууль тогтоомжийн дагуу хянан шийдвэрлэхтэй холбогдсон харилцааг зохицуулах;

**Сонгон шалгаруулалтад оролцогчид тавигдах шалгуур:**

- Анагаах ухаан, хууль, эрх зүй, нийгмийн ухаан, сэтгэл судлалын мэргэжлийн чиглэлээр дээд боловсрол эзэмшсэн мэргэшсэн этгээд, нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллагын болон үйлчлүүлэгчийн төлөөлөл байх;
- 8-аас доошгүй жил ажилласан ажлын туршлагатай байх;
- Эрүүгийн хариуцлага хүлээж байгаагүй байх;
- Ёс зүйн зөрчилд холбогдож байгаагүй байх;
- Ёс зүйн чиглэлээр сургалтад хамрагдсан байх;

**Бүрдүүлэх материал:**

- Төрийн албан хаагчийн маягт
- Төгссөн их, дээд сургуулийн дипломын хуулбар;
- Мэргэшсэн, сургалт дамжаанд хамрагдын сургалтын гэрчилгээ, үнэмлэхний хуулбарууд;
- Ёс зүйн сургалтад хамрагдсан гэрчилгээ, сертификатны хуулбар;
- Эмч, эмнэлгийн мэргэжилтэн нь мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн гэрчилгээний хуулбарыг заавал хавсаргах;
- Ёс зүйн зөрчилгүйг илэрхийлсэн тодорхойлолт;
- Иргэний үнэмлэхний хуулбар;

Дээрх шаардлагыг бүрэн хангасан материалыг (зөвхөн цаасаар) УНТЭ-ийн Захиргааны 5 давхарт шилэн өрөө, Захиргаа, хүний нөөцийн албанд 2026.04.17-ны өдрийн 15.00 цаг дуустал хугацаанд хүлээн авна.

УНТЭ-ийн Захиргаа, хүний нөөцийн алба  
2026.04.06